

Санхүүгийн тайлангийн аудитын чанарын асуудал

Challenges Pertaining to the Quality of Financial Reporting Audits

Т. Лагнай¹, Д. Нямаа², Д. Авирмэд³, Л. Хишигбаяр⁴

Хураангуй

Санхүүгийн тайлангийн аудит нь тухайн байгууллагын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого үнэн зөв, алдаагүй эсэхийг баталгаажуулахад чиглэнэ. Энэ нь зөвхөн хуулийн этгээд, хараат бус аудиторын хоорондын харилцаа биш, мөн мэдээлэл хэрэглэгчдэд цаг хугацаа, зардал хэмнэсэн, найдвартай мэдээлэл хүргэх чухал үйлчилгээ юм. Олон Улсын Аудит ба Баталгаажуулалтын Стандартын Зөвлөлийн баталсан стандартууд нь аудитын чанарыг сайжруулах үндэс боловч нөлөөлөх олон хүчин зүйлийн зөвхөн нэг хэсэг гэдгийг онцолдог. Монголд 2023 оны байдлаар 185 аудитын компани үйл ажиллагаа явуулж байгаа нь аудитын үйлчилгээний чанарт илүү анхаарах шаардлагатайг харуулж байна. Иймээс энэхүү судалгаагаар аудитын чанарт нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох, мэдээлэл хэрэглэгч болон удирдлагын сэтгэл ханамжийг үнэлэх, сайжруулах арга зам санал болгохыг зорьсон.

Түлхүүр үгс: санхүүгийн тайлан, аудитын чанар, хараат бус, хүчин зүйлс, мэдээллийн чанар

Abstract

The financial statement audit aims to verify whether a legal entity's accounting policies and financial statements are accurate and free of error. It is not only a relationship between the entity and independent auditors but also a valuable service that delivers cost-effective, reliable information to users. While the standards issued by the International Auditing and Assurance Standards Board provide a foundation for audit quality, they represent just one of several influencing factors. Internationally, auditor independence and service quality are regarded as critical, with extensive research conducted in the area. As of 2023, 185 audit firms are active in Mongolia, raising concerns over the quality of audit services. This study aims to identify the main factors affecting audit quality, assess whether users and company management are satisfied with audit outcomes, and propose recommendations for improving audit service quality from both theoretical and practical perspectives.

Keywords: financial reporting, audit quality, independence, factors, information quality

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: lagnai@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: d.nyamaa@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: avirmedd@num.edu.mn

⁴ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: khishigbayar@num.edu.mn

Удиртгал

Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээ нь аливаа аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн мэдээлэл үнэн зөв, алдаагүй эсэхийг үнэлж дүгнэх, тухайн мэдээлэлд итгэх үндэслэл бүхий баталгаа олгох чухал мэргэжлийн үйлчилгээ юм. Аудитын үйлчилгээ нь зөвхөн аудит хүлээн авагч болон аудитын үйлчилгээ үзүүлэгчийн хоорондын гэрээний харилцаа төдийгүй, өргөн хүрээний оролцогч талууд, тухайлбал хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, зохицуулагч байгууллагууд болон олон нийтэд хамааралтай мэдээллийн баталгаат байдлыг хангахад чиглэдэг. Иймд аудит нь нийгэмд итгэлцэл бий болгох, мэдээлэлд үндэслэсэн оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих стратегийн ач холбогдол бүхий үйлчилгээ хэмээн хүлээн зөвшөөрөгддөг.

Өнөөгийн нөхцөлд, мэдээллийн хүртээмж, үнэн зөв байдал нь зах зээлийн үр ашигтай байдал, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад шууд нөлөөлж байна. Тиймээс аудитын үйлчилгээний чанар, түүний найдвартай байдал нь зөвхөн аудитын байгууллагын дотоод зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхаас гадна олон улсын стандарт, хууль эрх зүйн орчны нөлөөн дор бүрэлддэг цогц ойлголт болжээ.

Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 185 аудитын компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь аудитын үйлчилгээний чанар, өрсөлдөөний орчин, мэргэжлийн хариуцлагын асуудлыг улам бүр чухалчилж үзэх шаардлагатай болгож байна. Компаниудын тоо нэмэгдэхийн хэрээр аудитын үйлчилгээний чанарт ялгаа бий болох, аудитын байгууллагын мэргэжлийн стандарт, ёс зүй, хараат бус

байдлыг хадгалах асуудлууд анхаарлын төвд орж буй. Иймээс энэхүү судалгааны ажлаар аудитын үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг онолын болон практикийн үүднээс авч үзэхийн зэрэгцээ, чанарын хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудыг тодорхойлон, цаашид аудитын чанарыг сайжруулах боломж, арга замын талаар санал, зөвлөмж боловсруулах зорилготой юм.

Судлагдсан байдал

Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний чанар нь олон улсын хэмжээнд эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсан, онол ба практикийн үүднээс өргөн хүрээтэйгээр судлагдсан сэдвийн нэг билээ. Судлаачид аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг олон талаас нь авч үзэж, институцийн хүчин зүйлс, мэргэжлийн ур чадвар, байгууллагын соёл, хараат бус байдал, аудитын үйл явцын онцлог, зохицуулалтын орчин, харилцагчийн онцлог зэрэг олон хэмжээст хүрээнд судалгаа явуулсан байдаг.

Жишээлбэл, Aronmwan нарын (2013) судалгаанд аудитын байгууллагын нэр хүнд ба үзүүлж буй үйлчилгээний чанарын хоорондын хамаарлыг олон хувьсагчийн регрессийн шинжилгээгээр судалжээ. Тэдний дүгнэлтээр аудитын үйлчилгээний чанарт хамгийн чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь аудитын байгууллагын нэр хүнд бөгөөд хэрэглэгчид нэр хүндтэй компанийг сонгох нь илүү чанартай, найдвартай аудитын баталгааг авах баталгаа болдог гэж үзсэн байна. Энэ нь үйлчилгээний чанарын талаарх ойлголтыг зөвхөн техникийн гүйцэтгэлээр бус, байгууллагын олон нийтийн дундах үнэлэмж, итгэлцэлтэй холбон судалсан онцлог судалгаа юм.

Мөн Oudda нарын (2023) судалгаа нь аудитын үйлчилгээний чанарт нөлөөлөх үйлчлүүлэгч болон аудиторын талаас хамаарах хүчин зүйлсийг анхаарч авч үзсэн. Тэд чанарын үнэлгээг түүвэрлэлтийн үндсэн дээр боловсруулсан асуулгын аргаар тоон үзүүлэлт болгон хэмжиж, аудитын үйлчилгээний чанарыг тодорхойлох аргыг боловсруулсан байна. Судалгааны онцлог нь чанарын ойлголтыг хэмжигдэхүйц үзүүлэлт болгон боловсруулж, хэрэглэгчийн хүлээлт, үнэлгээг тооцон авч үзсэн явдал юм.

Харин Sulaiman нар (2018) архивын судалгааны аргачлалаар аудитын чанарт дотоод хүчин зүйлсийн нөлөөллийг шинжилсэн. Тэд аудитын чанарын талаарх ойлголтыг өргөжүүлэхэд аудитын байгууллагын дотоод зохион байгуулалт, бодлого, менежмент зэрэг нь чухал үүрэгтэй болохыг тэмдэглэсэн. Судалгаанд практик нөхцөл байдлын талаарх мэдээлэл хомс байдал, түүнийг нөхөхөд чиглэсэн эмпирик мэдээллийн хэрэглээний ач холбогдлыг онцолжээ.

Эдгээр судалгаанууд нь аудитын үйлчилгээний чанарын тухай ойлголтыг онолын түвшинд гүнзгийрүүлэхийн зэрэгцээ, практик дээр тулгарч буй бэрхшээлүүдийг бодитоор илрүүлэн үнэлж, үйлчилгээний чанарын талаарх олон өнцөгт дүн шинжилгээ хийхэд бодит хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн, аудиторын хараат бус байдал, нэр хүнд, үйл явцын хяналт, хууль эрх зүйн орчны нөлөө зэрэг хүчин зүйлс нь аудитын чанарт нөлөөлөх цогц шинжтэй байдлыг баталж байна.

Судалгааны үр дүнгийн тойм

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь аудитын үйлчилгээний чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг аудитор, үйлчлүүлэгч байгууллагын зүгээс үнэлэн тодорхойлох, түүнчлэн аудитын чанарын хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг алдааг задлан шинжлэхэд оршино. Судалгааны хүрээнд холимог судалгааны арга (mixed methods approach) ашигласан ба асуулга, ярилцлага, хоёрдогч мэдээллийн шинжилгээ хослон хэрэглэгдсэн.

Түүврийн бүрдүүлэлт ба судалгааны бүтэц

Судалгаанд нийт гурван эх сурвалжаас мэдээлэл цуглуулсан. Үүнд:

- 42 аудитор: мэргэжлийн аудиторууд болон аудитын багийн гишүүдээс бүрдсэн түүвэр;
- 73 үйлчлүүлэгч байгууллагын төлөөлөл: удирдлагууд болон нягтлан бодогч нар;
- Чанарын хяналтын албан ёсны мэдээлэл: Сангийн яам, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ) болон бусад хяналтын байгууллагын 2018-2022 оны аудиторын чанарын хяналтын тайлан, шалгалтын үр дүн.

Судалгааны асуулгыг “Google Forms” платформ ашиглан боловсруулсан ба асуулгыг хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийхэд зардал багатай, хүртээмжтэй, найдвартай хэрэгсэл болохыг харгалзан үзсэн. Аудиторуудад зориулсан асуулга 15 гол асуултаас бүрдсэн бол үйлчлүүлэгч байгууллагын төлөөлөл болох нягтлан бодогчдод 10 асуулт бүхий судалгаа явуулсан. Мөн зарим респонденттэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн.

Хүснэгт 1. Аудиторуудаас авсан асуулга, хариултын багц

Асуулт	Тийм	Заримдаа	Үгүй
1. Аудитын багийн гишүүд ёс зүйн зарчмуудыг баримталж ажилладаг эсэх	32	7	3
2. Аудитын хуулийн этгээд болон аудиторууд үйлчлүүлэгч байгууллагаас хараат бус ажилладаг эсэх	17	21	4
3. Аудитын багийн ахлах, гишүүд үйлчлүүлэгч байгууллагын гүйцэтгэх удирдлагатай шууд харилцах боломжтой эсэх	32	7	3
4. Аудиторууд нэг байгууллагад тогтвортой ажилладаг эсэх	14	19	9
5. Нэг ажилтанд ногдох ажлын ачаалал	11	16	15
6. Ажлын байран дээр шинээр гарсан СТОУС, хууль журмын талаар сургалт явуулдаг эсэх	23	9	0
7. Аудитор, туслах ажилтнууд нь аудитыг явуулахад хүрэлцээтэй техник хэрэгслээр хангагдсан эсэх	8	26	8
8. Аудитын хуулийн этгээдийн ажилтнууд гэрээт ажлыг гүйцэтгэхэд хангалтгүй байх үед гаднаас ажиллах хүчин хөлслөхөд тавигдах шаардлага, нөхцөлийг зохицуулсан бодлого журам эсхүл гэрээ байгаа эсэх	9	31	2
9. Аудиторын ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал ашигладаг эсэх	17	19	6
10. Аудитын хуулийн этгээд нь үйлчлүүлэгч шинээр/үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөхтэй холбоотой бичигдсэн бодлого, горим бий эсэх	13	25	4
11. Эрсдэл өндөртэй үйлчлүүлэгч хүлээн зөвшөөрөх үед баримтлах арга барилыг бодлого, журмаар зохицуулсан эсэх	2	28	12
12. Гэрээт ажлаас татгалзах талаар тогтсон шалгуур эсхүл горим, журам бий эсэх	1	33	8
13. Аудитор нь үйлчлүүлэгч байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай ажилтнуудаар багаа бүрдүүлдэг эсэх	9	31	2
14. Аудитын багийнхан аудитын горим ашиглаж ажилладаг эсэх	34	8	0
15. Ажлын баримтууд дээр тухайн аудитын горимтыг бэлтгэсэн хүний нэр эсхүл тэр хүнийг таних тэмдэг, гүйцэтгэсэн огноо, хянаж шалгасан, баталсан огноог тэмдэглэж баримтжуулдаг эсэх	40	2	0

Судлаачдын нэгтгэл

Аудиторуудаас авсан үр дүнгийн тойм
(Хүснэгт 1)

Аудиторын хариултаас харахад:

- 76% нь (32 хүн) ёс зүйн зарчмыг баримталдаг гэж мэдэгдсэн;
- 40% нь л үйлчлүүлэгч байгууллагаас бүрэн хараат бус ажилладаг гэж үзсэн бол 50% нь “заримдаа” гэж хариулсан нь хараат бус байдал туйлын баталгаатай биш байгааг илтгэв;
- Аудитын багийн гишүүдийн ур чадвар, горимын баримтлал, баримтжуулалт

харьцангуй сайн байгаа хэдий ч (жишээлбэл, 95% нь аудитын горимыг баримталдаг гэжээ), техник хэрэгслээр хангалт хангалтгүй (зөвхөн 8 хүн “тийм” гэж хариулсан);

- Гэрээт ажил гүйцэтгэхэд гадаад нөөц ашиглах бодлого дутмаг, эрсдэлтэй үйлчлүүлэгчтэй харьцах журам тодорхойгүй, гэрээ цуцлах шалгуур сул зэрэг менежментийн бодлого, журам, дотоод хяналтын зохицуулалтын асуудлууд илт дутагдалтай байв.

Хүснэгт 2. Нягтлан бодогчдоос авсан асуулга, хариултын багц

Асуулт	Тийм	Заримдаа	Үгүй
1. Аудиторууд танай байгууллагын бизнесийн онцлогийг ойлгож, үйлчилгээ үзүүлдэг эсэх	27	30	6
2. Аудитор нь үйлчлүүлэгч байгууллагын салбарын мэдлэгтэй, ур чадвар, дадлага туршлагатай эсэх	22	38	3
3. Аудитын багийн гишүүд ёс зүйн зарчмуудыг баримталж ажилладаг эсэх	18	36	9
4. Аудиторууд нэг байгууллагад тогтвортой ажилладаг эсэх	6	41	16
5. Аудитын хуулийн этгээд болон аудиторууд үйлчлүүлэгч байгууллагаас хараат бус ажилладаг эсэх	28	24	11
6. Нягтлан бодогч удирдлагууд аудиторын гаргасан дүгнэлт зөвлөмжтэй санал нийлдэг эсэх	12	38	13
7. Аудиторууд дүгнэлт, зөвлөмжөө мэргэжлийн стандарт, хууль тогтоомжтой уялдуулан үндэслэлтэй гаргадаг эсэх	9	38	16
8. Аудиторын баг үйлчлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний хугацаандаа аудитын үйлчилгээг үзүүлж дуусгадаг эсэх	42	19	2
9. Аудитын үйлчилгээний чанар нь төлж буй үйлчилгээний хөлстэй уялддаг эсэх	10	45	8
10. Аудитын үйлчилгээ нь танай хүлээж байсан үр дүнд хүрдэг эсэх	6	31	26

Судлаачдын нэгтгэл

Нягтлан бодогчдоос авсан үр дүнгийн тойм (Хүснэгт 2)

Нягтлан бодогчид аудитын үйлчилгээний чанарт хандах хандлага, үнэлгээний хувьд:

- Аудиторуудын бизнесийн онцлогийг ойлгох чадварыг 37% нь “тийм”, 41% нь “заримдаа” гэж үнэлсэн;
- 53% нь аудитын баг мэргэжлийн ёс зүйн зарчим баримталдаг гэж үзэж буй нь харьцангуй эерэг үнэлгээтэй;
- Хараат бус байдлыг 38% нь бүрэн хангасан гэж үзсэн ч 34% нь “заримдаа” гэж хариулсан;
- Хамгийн анхаарал татсан үр дүн нь аудитын үйлчилгээний үнэ хөлсийг “илүү өндөр” гэж үнэлсэн нягтлан бодогчид 45% байгаа нь зах зээлийн үнэлгээ, үйлчилгээний чанарын уялдаа сул байгааг илтгэнэ;
- Мөн аудитын үйлчилгээ хүлээлтэд хүрдэг эсэх тухайд 26 хүн буюу 35% нь “хүрдэггүй” гэж үнэлсэн нь аудитын үр

өгөөж, сэтгэл ханамжид сөрөг үнэлгээ өгч буйг харуулж байна.

Чанарын хяналтын үр дүн

Сангийн яам, ММНБИ зэрэг байгууллагуудаас жил бүр зохион байгуулдаг чанарын хяналтын шалгалтын 2018-2022 оны мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд:

- 198 аудитын хуулийн этгээд хамрагдаж, тэднээс 68% буюу 135 нь хангалттай үнэлгээ авсан;
- 27% буюу 53 нь “сайжруулах шаардлагатай”, 4% буюу 8 нь “хангалтгүй”, 2 этгээд “хүчингүй болгох хүсэлт” гаргасан байна.
- Хяналтын явцад нийтлэг илэрдэг зөрчлүүд нь ажлын баримтын бүрдэл дутуу байх, хяналтын горим хангалтгүй, нотлох баримтыг үндэслэлгүй тайлагнасан зэрэг аудитын ажлын чанарт нөлөөлөх үндсэн алдаа дутагдлууд байв.

Чанарын хяналт шалгалтын явцад аудитын хуулийн этгээдүүдийн нийтлэг гаргадаг алдаа, доголдлыг дараах үндсэн чиглэлээр ангилан тодорхойлсон. Үүнд:

- **Хараат бус байдлыг хангахгүй байх:** Аудитын байгууллагын зарим ажилтан, багийн гишүүд үйлчлүүлэгч байгууллагын удирдлагатай хэт ойр харилцаатай байх, эсвэл хараат бус байдлыг бүрэн хангаж чадахгүй байх тохиолдлууд илэрсэн;
- **Ажлын хариуцлага, хандлагын дутагдал:** Аудитын гүйцэтгэлийн явцад хариуцлага сул, хандлага мэргэжлийн түвшинд хүрэхгүй байх, үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй байдал ажиглагдсан;
- **Шинээр үйлчлүүлэгч хүлээн авах үйл явцын баримтжуулалт хангалтгүй:** Шинэ үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулах үед шаардлагатай маягт, зөвшөөрөл, үнэлгээний хуудас зэргийг бөглөж баталгаажуулдаг журам мөрдөгдөхгүй байх тохиолдол олонтоо байсан;
- **Аудитын горимыг бүрэн хэрэгжүүлдэггүй:** Аудитын төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ, гүйцэтгэлийн үе шат зэрэг үндсэн горимыг албан ёсоор мөрдөхгүй, эсвэл зөв баримтжуулахгүй байх дутагдал нийтлэг илэрсэн;
- **Ажлын баримтын бүрдүүлэлт хангалтгүй:** Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, хяналтын мөр, аудитын дүгнэлтэд шаардлагатай нэмэлт мэдээлэл зэрэг нь бүрэн бүрдүүлэгдээгүй, тухайн ажлын баримтад шаардлагатай тэмдэглэгээ, хяналт баталгаажуулалт хийгдээгүй байх тохиолдлууд байв;
- **Цалин урамшууллын тогтолцоо тодорхойгүй, уялдаа сул:**

Ажиллагсдын гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшууллын бодлого нь аудитын ажлын чанартай уялдахгүй, эсвэл дотоод зохицуулалт хангалтгүй байгааг хяналт шалгалтын дүгнэлтүүдээс харж болно.

Эдгээр алдаа, доголдлууд нь аудитын үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул цаашид бодлого, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэгдэж байна.

Дүгнэлт

Санхүүгийн тайлангийн аудит нь мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангах замаар хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад үнэтэй хувь нэмэр оруулдаг мэргэжлийн чухал үйлчилгээ юм. Судалгааны үр дүнгээс харахад аудитын үйлчилгээний чанарт нөлөөлдөг гол хүчин зүйлс нь аудитын багийн мэргэжлийн ёс зүй, ур чадвар, хараат бус байдал, ажлын гүйцэтгэл, мөн байгууллагын дотоод хяналт, бодлого зохицуулалттай шууд холбоотой байна. Аудиторын зүгээс үзүүлж буй үйлчилгээний чанар, үйлчлүүлэгч байгууллагын хүлээлт хоёрын хооронд тодорхой зөрүү байсаар байна.

Аудиторуудын зүгээс хараат бус байдлыг хангах, аудитын горимыг бүрэн хэрэгжүүлэх, ажлын нотлох баримтын бүрдлийг гүйцэд хийх, гадаад нөөц ашиглалтын бодлогыг тодорхой болгох, шинэ үйлчлүүлэгчийг хүлээн авах журам, гэрээ цуцлах шалгуур, урамшууллын уялдаа зэргийг сайжруулах шаардлагатай байна. Харин үйлчлүүлэгч байгууллагууд аудитын чанарыг зөвхөн хөндлөнгийн дүгнэлтээр бус, байгууллагын нэр хүнд, зөвлөгөө өгдөг чадвар, салбарын онцлогийг ойлгох байдал зэргээр илүү өргөн хүрээнд үнэлж буй нь анзаарагдлаа.

Чанарын хяналтын дүнгээс үзэхэд аудитын хуулийн этгээдийн 27% нь сайжруулах шаардлагатай, 4% нь хангалтгүй үнэлгээ авч байсан нь аудитын системийн чанарын хяналт, хариуцлагын тогтолцоо нэмэлт анхаарал шаарддагийг нотолж байна.

Энэхүү судалгаагаар аудитын үйлчилгээний чанарт нөлөөлөх цогц хүчин зүйлсийг онолын болон практикийн

түвшинд судалж, чанартай, хараат бус, хариуцлагатай аудитын үйлчилгээг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогын түвшний зөвлөмж гаргах үндэслэлийг бүрдүүллээ. Цаашид аудитын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахын тулд хүний нөөцийн чадавх, дотоод хяналтын бодлого, стандартын хэрэгжилтийг олон улсын чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх нь чухал байна.

Ашигласан материал

Federation of European Accountants. (2015). *Overview of Audit Quality Indicators Initiatives: Update to December 2015 Edition*.

Aronmwan, E. J., Ashafoke, T. O., & Mgbame, C. O. (2013). Audit Firm Reputation and Audit Quality. *European Journal of Business and Management*, 5(7), 66-75.

Oudda, M., Outellou, S., & Abdelbaki, N. (2023). Factors Impacting Audit Quality: A Systematic Literature Review. *Revue Française d'Économie et de Gestion*, 4(9), 177-209.

Sulaiman, N. A., Mat Yasin, F., & Muhamad, R. (2018). Perspectives of Audit Quality: An Analysis. *Asian Journal of Accounting Perspectives*, 11(1), 1-27. <http://dx.doi.org/10.22452/AJAP.vol11no1.1>

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (2018). *Аудитын олон улсын стандартууд*.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (2011). *Чанарын хяналтын олон улсын стандарт*.

Аудитын тухай хууль. (2020). Монгол Улс.

Алтанзаяа, Г., Баттуяа, Д. (2015). *Аудит*. Улаанбаатар: МУИС-Хэвлэх үйлдвэр.

Гантулга, Г. (2013). *Аудит*. Улаанбаатар: Соёмбо Пресс.